

2026 он 03 сар 18 өдөр

Дугаар 26/02

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Нэгж эрх эзэмшигчдийн хурал
зарлан хуралдуулах тухай*

Монгол Улсын Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журмын 9 дүгээр зүйлийн зохицуулалтыг тус тус үндэслэн “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “**Хурал**” гэх)-ыг 2026 оны 4 сарын 28-ны өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал Тауэрийн 17 давхарт зарлан **ХУРАЛДУУЛСУГАЙ**.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралтаар, Нэгж эрх эзэмшигчдийн хурлын дэгийг Хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг Гуравдугаар хавсралтаар, Саналын хуудасны агуулга, загварыг Дөрөвдүгээр хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт материалын жагсаалтыг Тавдугаар хавсралтаар тус тус **БАТАЛСУГАЙ**.
3. Хуралд оролцох эрхтэй Нэгж эрх эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4 сарын 8-ны өдрөөр **ТОГТООСУГАЙ**.
4. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 3 дугаар сарын 20-ны өдрийн дотор **ХҮРГҮҮЛСҮГЭЙ**.
5. Хурлын зарыг 2026 оны 3 сарын 23-ны өдөр Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, хоёроос доошгүй өдөр тутмын сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд зарласугай. Давтан зарыг 2026 оны 4 сарын 7-ны өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр **ДАМЖУУЛСУГАЙ**.

6. Нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, танилцуулга зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2026 оны 3 сарын 27-ны өдрийн дотор үнэт цаасны компаниудад **ХҮРГҮҮЛСҮГЭЙ**.
7. Нэгж эрх эзэмшигчдийн хуралд оролцох боломжгүй нэгж эрх эзэмшигчдийн санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 16:00 цагаар тасалбар **БОЛГОСУГАЙ**.
8. Нэгж эрх эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг Ард Аппликейшн болон цаасан хэлбэрээр хослуулан **АВСУГАЙ**.
9. Хурлын даргаар “Ард Менежмент” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Даваасамбууг **ТОМИЛСУГАЙ**.
10. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр **ТОМИЛСУГАЙ**. Үүнд:
 - Хурал зохион байгуулах комиссын дарга:
 - “Ард Менежмент” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Даваасамбуу;
 - Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
 - “Ард Менежмент” ХХК-ийн Сангийн менежер У.Сүхдарь;
 - “Ард Менежмент” ХХК-ийн Сангийн менежер Т.Батбаяр.
11. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр **ТОМИЛСУГАЙ**. Үүнд:
 - Тооллогын комиссын дарга:
 - Ө.Бямбагэрэл (Ард Секюритиз ҮЦК ХХК);
 - Тооллогын комиссын гишүүд:
 - Ч.Даваацэрэн (Ард Секюритиз ҮЦК ХХК);
 - Б.Эрдэнэбилэг (Ард Секюритиз ҮЦК ХХК).
12. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст **ДААЛГАСУГАЙ**.
13. Нэгж эрх эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ч.Даваасамбууд **ДААЛГАСУГАЙ**.

ДАРГА



Б.ЗОЛБОО

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 3-р сарын 18-ны өдрийн
26/2 дугаар тогтоолын Хавсралт 1



НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Ард Менежмент ХХК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлан;
2. 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
3. Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан;
4. 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлт;
5. “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС ХХК-ийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах;
6. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
7. ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай;
8. Кастодиан банк өөрчлөх шийдвэрийг батлах;
9. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
10. “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн хөрөнгө оруулалтын бодлогод өөрчлөлт оруулах;
11. “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн нэгж эрхийн танилцуулгад өөрчлөлт оруулах.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 3-р сарын 18-ны өдрийн
26/22 дугаар тогтоолын Хавсралт 2



НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

№	Дэд хэсэг	Цаг
1	Хурлын ирцийг бүртгэх /тооллогын комисс/	14:50-15:15
2	Хурлын ирцийг мэдээлэх /тооллогын комисс/	15:15-15:20
3	Хурлын дарга хурлыг нээж, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах;	15:20-15:30
4	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, санал хураалт явуулах;	15:30-16:20
5	Хэлэлцэх асуудал тус бүрээр санал хураалт;	16:20-16:30
6	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах;	16:30-16:45
7	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах;	16:45-16:55
8	Хурлыг хаах	17:00

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 3-р сарын 18-ны өдрийн
26/02 дугаар тогтоолын Хавсралт 3



ХУРЛЫН ЗАР
“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХОС-ИЙН
НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 сарын 28-ны өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал Тауэр 17 давхарт болох тул нэгж эрх эзэмшигч та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

1. Ард Менежмент ХХК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлан;
2. 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
3. Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан;
4. 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлт;
5. “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС ХХК-ийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах;
6. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
7. ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай;
8. Кастодиан банк өөрчлөх шийдвэрийг батлах;
9. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
10. “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн хөрөнгө оруулалтын бодлогод өөрчлөлт оруулах;
11. “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн нэгж эрхийн танилцуулгад өөрчлөлт оруулах.

Нэгж эрх эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь: **2026 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр** байна.

Хуралд бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:

1. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх Саналын хуудасны загвар;
2. Нэгж эрх эзэмшигчдийн хурлын дэг;
3. Нэгж эрх эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл.

Нэгж эрх эзэмшигч та бүхэн хуралдаа итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан оролцож болох ба ажлын өдрүүдэд 09:00 – 18:00 цагийн хооронд Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, соёл амралтын хүрээлэн /14240/, энхтайвны өргөн чөлөө, 17, Блю Скай Тауэр 9 давхарт байрлах “Ард Секюритиз ҮЦК” ХХК-аар дамжуулан санал авах хуудсаар болон Ард Апп-аар саналаа урьдчилж өгөх боломжтой. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацаа 2026 оны 4 сарын 24-ний өдрийн 15:00 цагт дуусна.

Доорх газруудад хандаж ээлжит хурлын материал, саналын хуудастай танилцана уу.

№	Байгууллагын нэр	Утас	Шуудангийн хаяг
1	Ард Секюритиз ҮЦК ХХК	(976) 77003322	info@ardsecurities.com
2	Ард Менежмент ХХК	(976) 99228288	info@ardmanagement.com suhdari.u@ardmanagement.mn

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 3-р сарын 18-ны өдрийн
26/02 дугаар тогтоолын Хавсралт 4



**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХАМТЫН ХОС
САНАЛ АВАХ ХУУДАС**

Нэгж эрх эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй эрхийн тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2026 оны 4 сарын 28-ны өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал Тауэр 17 давхарт хуралдах “Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Хэлэлцсэн асуудлын нэр	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
1	Ард Менежмент ХХК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлан	Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай				
2	2025 оны үйл ажиллагааны тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах	2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай				
3	Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан	Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай				
4	2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт	Хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг батлах тухай				
5	Үндэсний Хувьчлалын Сан Хамтын ХОС-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Үндэсний Хувьчлалын Сан Хамтын ХОС-ийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай				
6	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсөв батлах	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсөв батлах тухай				

№	Хэлэлцсэн асуудлын нэр	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
7	Кастодиан банк өөрчлөх	Кастодиан банк өөрчлөх тухай				
8	Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүдийг сонгох 1 2 3 4 5 Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгох 1 2 3 4		Нэр дэвшигчид өгөх саналын тоо /кумулятив аргаар/ 			
9	“Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн хөрөнгө оруулалтын бодлогод өөрчлөлт оруулах;	Хөрөнгө оруулалтын бодлогод өөрчлөлт оруулах тухай				
10	“Үндэсний Хувьчлалын Сан” Хамтын ХОС-ийн нэгж эрхийн танилцуулгад өөрчлөлт оруулах.	Нэгж эрхийн танилцуулгад өөрчлөлт оруулах тухай				

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Нэгж эрх эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Ард аппликейшн болон Ард Секюритиз ҮЦК ХХК-д биечлэн очиж, хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар урьдчилан саналаа өгч болно.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл олгож нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.

Нэгж эрх эзэмшигчийн гарын үсэг _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2026 оны -р сарын өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____ / _____ /

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 3-р сарын 18-ны өдрийн
26/02 дугаар тогтоолын Хавсралт 5



**НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ
ХОЛБОГДОХ БАРИМТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ**

№	Танилцах баримт бичгүүд	Бэлэн болох хугацаа
1	Нэгж эрх эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төслүүд	2026/03/27
2	Нэгж эрх эзэмшигчдийн хурлын дэг	2026/03/18
3	Нэгж эрх эзэмшигчдийн хурлын саналын хуудасны загвар	2026/03/18
4	Нэгж эрх эзэмшигчдийн хурлын материал	2026/03/27